



“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 03 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар ТУЗ2026-03/02

Улаанбаатар
хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйл, 62 дугаар зүйл, 64 дүгээр зүйл, 65 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Таван Богд Холдингс” ХХК-иас 2026 оны 02 дугаар сард ирүүлсэн санал, “Жуулчин Дюти Фрий ХК-ийн дүрмийн 7-р зүйлийн 7.1, 7.2, 7.3 дах хэсэг, 8-р зүйлийн 8.9.3 дэх хэсгийг тус тус үндэслэн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС ТОГТООХ нь:

1. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04-р сарын 30-ны өдрийн Пүрэв гарагийн 16:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Ганди гудамж, Барилгын төслийн талбайд байрлах оффисын 1-р давхарт байрлах хурлын танхимд хуралдуулахаар тогтоосугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:

- 2.1 Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах;
- 2.2 Төлөөлөн удирдах зөвлөлөөс санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг хэлэлцэн, батлах;
- 2.3 Компанийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын компанийн дүгнэлтийг танилцуулах;
- 2.4 Компанийн 2025 оны ногдол ашгийн тухай гаргасан ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах;
- 2.5 Компанийн 2026 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг танилцуулах, батлах
- 2.6 “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, батлах;
- 2.7 “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр томилох, батлах;

3. Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Хавсралт №1-ээр баталж, 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн дотор багтаан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг хавсралт №2-оор баталж 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Монголын хөрөнгийн бирж, болон өөрийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, мөн 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр анх мэдээлсний дагуу дахин хурлын зарыг хүргэхээр тогтоосугай.

5. Хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичигтэй ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ /Утас:95034477, Tbpro-legalcounsel@tavanbogd.com/ -тэй холбогдон танилцах боломжтойг болохыг мэдээлсүгэй.

6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой бичиг баримтыг 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор багтаан хувьцаа эзэмшигчдэд болон тэдгээрт үйлчилж буй брокер, дилерийн компанид хүргүүлсүгэй.

7. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр байхаар тогтоосугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд биечлэн оролцох боломжгүй, саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацааг 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 17:00 цаг хүртэл тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Гүйцэтгэх захирал Ц.Отгонбаярыг томилсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Э.Оюунпүрэв, гишүүнээр Э.Дарьцэцэг нарыг тус тус томилсугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулахтай холбоотой зардлыг компаниас гаргахыг Гүйцэтгэх захирал Ц.Отгонбаярт зөвшөөрсүгэй

12. Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлж, хуралд бэлтгэх, хурал зохион байгуулах бэлтгэх ажлыг ханган ажиллахыг Хурлын дарга Ц.Отгонбаяр, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ нарт даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ц.БААТАРСАЙХАН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр	"Жуулчин Дютри Фрий" ХК
Хаяг, утас	Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Стадион оргил, Хаан банк цамхаг, 9-р давхар, Утас: 95034477
Хурал хуралдах өдөр, цаг	2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 16:00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Ганди гудамж, Барилгын төслийн талбайд байрлах оффисын 1-р давхарт байрлах хурлын танхимд
Хурлын төрөл:	Ээлжит хурал
Хурал зарлагч	Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо	2026 оны 03-р сарын 20-ны өдөр
Олон нийтэд зарлах огноо	2026 оны 03 -р сарын 25-ны өдөр
Бүртгэх өдөр	2026 оны 04-р сарын 13-ны өдөр
Хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо	2026 оны 04-р сарын 01-ний өдөр
Хүргүүлсэн огноо	2026 оны 04-р сарын 01-ны өдөр
Хурлын даргын нэр	Ц.Отгонбаяр
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр	Тооллогын комиссын дарга Э.Оюунпүрэв Тооллогын комиссын гишүүн Э.Дарьцэцэг
Баримт, бичгийн жагсаалт /хавсралтаар/	1. "Жуулчин Дютри Фрий" ХК-ийн ХЭ-ийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн 2026.03.20-ны өдрийн тогтоол 2. ХЭ хурлын мэдэгдэл 3. ХЭ-ийн хурлын зарын загвар 4. "Жуулчин Дютри Фрий" ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан
Баримт, бичгийн хуудасны тоо	6 хуудас

ХУРЛЫН ДАРГА /Ц.ОТГОНБАЯР/



**Өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгөх
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар**



**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Пүрэв гарагийн 16:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Ганди гудамж, Барилгын төслийн талбайд байрлах оффисын 1-р давхарт байрлах хурлын танхимд болно.

Хурлаар хэлэлцэх асуудал

- Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах
- Төлөөлөн удирдах зөвлөлөөс санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг хэлэлцэн, батлах
- Компанийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын компанийн дүгнэлтийг танилцуулах,
- Компанийн 2025 оны ногдол ашгийн тухай гаргасан ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах,
- Компанийн 2026 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг танилцуулах, батлах
- “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, батлах;
- “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр томилох, батлах;

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04-р сарын 13-ны өдөр байна.

Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй БДК-иуд болон компанийн байранд 2026 оны 4-р сарын 01-ний өдрөөс ирж танилцаж боломжтой.

Хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг компанийн байранд болон хурал зохион байгуулах комиссын утсаар холбогдон авна уу.

Хаяг: Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Стадион оргил, Хаан банк цамхаг, 9-р давхарт ажлын өдрөөр 08:30-17:30 цагийн хооронд

Утас: 95034477 утсаар холбогдоно уу.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС